

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны
...12... дугаар сарын ...27...-ны өдрийн ...
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

М/НО

Байгууллагын нэр:

Мөрдөн байцаах алба

Нэгжийн нэр:

Захиргааны удирдлагын хэлтэс

Албан тушаалын нэр:

Эрүүл мэнд, биеийн тамир,
хөдөлмөр хамгааллын арга зүйч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-6

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо,
Самбуугийн гудамж 18

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын
гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон
бусад аюул тохиолдсон, нийтийн эмх
замбараагүй байдал үүссэн, террорист
халдлага, онц болон дайны байдал зарласан,
онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг
зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар
болон өндөржүүлсэн бэлэн байдалд
ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго: "Монгол Улсын Үндсэн хууль", "Цагдаагийн албаны тухай хууль", "Эрүүл мэндийн тухай хууль", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль" болон бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн акт, эмнэлгийн стандарт, цагдаагийн байгууллагад мөрдөгдөх дүрэм журмын дагуу чиг үүргийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн технологи, эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлийн /MNS:4621:2008/ стандартыг баримталж, биеийн тамир, хөдөлгөөн засал эмчилгээг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Албан тушаалын зорилт:

1.Алба хаагчдад үзүүлэх биеийн тамир, хөдөлгөөн засал, эмчилгээг чанар, хүртээмжтэй хийж, эрүүл мэндийн технологи, эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлүүд /MNS:4621:2008/ стандартыг мөрдөж, биеийн тамир, хөдөлгөөн засал эмчилгээг чанартай хийх.

2.Алба хаагчдыг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх урам зоригийг нэмэгдүүлж, хөдөлгөөний дутагдал, таргалалтаас сэргийлэх.

3.Алба хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хяналт тавих.

4.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Эрүүл мэндийг хамгаалах технологи. Эмчилгээ, үйлчилгээний түгээмэл үйлдлийн /MNS:4621:2008/ стандарт, сэргээн засах эмчилгээтэй холбоотой дүрэм, журмыг баримтлан ажиллах; 1.2.Алба хаагчдын эрүүл мэндийг байнга хянаж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч, санал хүсэлтийг хүлээн авч үйлчлэх; 1.3.Албаны нууцад тавигдах шаардлагыг хангаж ажиллах;	Хөдөлгөөн засал эмчилгээний стандарт мөрдөгдсөн байна.	Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Алба хаагчдыг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх урам зоригийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажил төлөвлөн зохион байгуулах; 2.2.Алба хаагчдыг хөдөлгөөний дутагдал, таргалалтаас сэргийлэх талаар үе шаттай сургалт зохион байгуулан биеийн тамираар хичээллүүлж Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Алба хаагчдыг мэргэжлийн зэргийн сургалтад хамруулах, шалгалт авах /код 948/ журам”-д заасан бие, бялдрын шалгуурыг хангадаг болгох; 2.3.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Алба хаагчийг сувилгах, эрүүл мэндийг нөхөн сэргээх /код 936/ журам”-ын 939.3.7-т заасан ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.	Эмчилгээ, сувилгаа тэгш хүртээмжтэй хүрсэн байна.	Г Г Г

3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг даган мөрдөж, алба хаагч, ажилтнуудад ажлын хувцас хэрэглэлийг бүрэн өмсгөх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангуулж, зааварчилгаа өгч, хяналт тавих; 3.2.Хэлтсийн даргын баталсан хуваарь, үүргийн дагуу даалгасан ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулах; 3.3.Хэлтсийн даргын баталсан хуваарь, үүргийн дагуу даалгасан ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулах;	Цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.	Г Г Г
Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	4.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх; 4.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 4.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	-	Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	-Анагаан ухаан /0912/, Сувилахуй ба эх барихуй /0913/, Сэргээн засал /0915/, Уламжлалт анагаан ухаан /0917/, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд хамаарах салбар дундын чиглэл /0988/, Спорт /1014/, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /1022/	
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	Цагдаагийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй.
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх.

		-Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах.
--	--	--

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

Шууд харилцах байгууллага:

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;

Шууд бус харилцах байгууллага:

-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Байгууллагын нэр:
Шийдвэрийн огноо:
Дугаар:.....

Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр
Дугаар: 27/401

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Т.СҮХБОЛД

ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:
.....
.....

20...оны ... дугаар сарын ...-ны өдөр